

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР 10 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

Барилга, хот байгуулалтын хэлтэс:


Аймгийн Засаг даргын 2023 оны А/262 дугаар захирамжаар удаашралтай байгаа барилга байгууламжын ажлуудад очиж ашиглалтад ороход хүндрэлтэй байгаа асуудал, шалтгааныг тодорхойлох, шаардлагатай арга хэмжээг шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр угсралт, тохижилтын 8-н ажлын талбайд газар дээр нь очиж ажиллалаа.

Мөн ажлын хэсгийн хүрээнд 2023.10.04 болон 2023.10.11-ний өдрүүдэд барилга угсралтын 4 компанитай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсгийн дүгнэлт зөвлөмжийг гаргах шатандаа ажиллаж байна.



Барилга захиалагчийн хяналтаар:

Шивээговь сумын 3-р цэцэрлэг 150 хүүхдийн өргөтгөлийн барилга: 1-р давхарын гадна дотор хана өрөгдөж дууссан. Гадна хана парapedны хэсэг, 2-р давхарын гадна ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Барилгын нийт өрлөгийн ажлын гүйцэтгэл 85 хувьтай. Барилгын ажлын гүйцэтгэл 63 хувьтай үргэлжилж байна.



Аймгийн төвийн 2000м3

цэвэрлэх байгууламжийн ажил: Захиргаа аж ахуйн барилгын ажил 1,2-р давхарын

төмөр бетон каркасын ажил бүрэн хийгдэж дууссан. Биоректорын барилгын цутгамал хийцлэл мөн дууссан гүйцэтгэгч улирлаас хамааралтай барилгын ажлыг түр зогсоож талбайгаас буусан байна.



Халуун усны барилга: барилгын гадна хана бүрэн өрөгдөж дууссан, дотор хана 85 хувийн гүйцэтгэлтэй, өрлөгийн шавардлагын ажил үргэлжилж байна. Талбайд 4 хүнтэй баригад ажиллаж байна ажлдын гүйцэтгэл 63 хувьтай. Ажлыг яаравчлах хүйтний улирлаас хамааралтай гүйцэтгэх ажлын дарааллыг оновчтой сонгож гүйцэтгэх чиглэл өгөөд байна.



Аймгийн төвийн 2,8км авто замын ажил: Авто замын ажлын гүйцэтгэл 75 хувьтай асфальт зам талбайн хучилтын ажил бүрэн дууссан хэвтээ босоо тэмдэглэгээ ус зайлуулах хоолой ажил нэмэлтээр, гэрэлтүүлгийн ажил, хавтан зам талбайн хучилт ажил үргэлжилж байна.



Худалдаачны гудамжны тохижилт: Дугуйн замын далангын үе бүрэн хийгдэж дууссан дугуйн замын хашлага суулгах ажил, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 45 хувьтай



0,36км автозамын ажил: ажлын гүйцэтгэл 80 хувьтай үндсэн автозамын ажил 90 хувьтай. Дугуйн зам явган замын ажил 55 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Трассын дагуу шугам сүлжээ давхцалын асуудлууд ажил удаашрах шалтгаан болж байна.



Боржигон чуулгын барилга: Барилгын ажлын гүйцэтгэл нийт гүйцэтгэл 60 хувьтай барилгын цонх сууссан металл фасад захиалага хийгдсэн 11 дүгээр сарын эхээр барилгын талбайд буух төлөвлөгөөтэй байна. Барилгын талбайд дотор хамар хана шаврын ажил хийгдэж байна. Дээврийн ажил техникийн давхарын угсралтын ажлыг хийж гүйцэтгэхээр гүйцэтгэгч компани төлөвлөөд ажиллаж байна.



Орон нутгийн өмчийн газруудын засвар: 4-р сургуулийн дээвэр засварын ажил 70 хувьтай, АЗДТГ-н засвар буулгалтын ажил эхэлж 10 хувьтай. Татварын хэлтсийн барилга 10 хувьтай. БОАЖГ-н барилгын засвар 60 хувьтай. Засварын ажил хийгдэж байна бараа материал тататлж 80 гаруй хувьтай талбайд буусан.



Газрын удирдлагын хэлтэс:

Шивээговь сумын 2-р багийн өдөрлөгийн үйл ажиллагаанд мэдээлэл хийж ажилласан.



Эмэгтэйчүүдийн манлайллын “Оюу” клуб, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулж буй **Идэвхтэн байгаль хамгаалагчийн идэвхжүүлэх** сургалтанд Газрын тухай хуулийн сэдвийн хүрээнд мэдээлэл өгч ажиллав.



Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Албан хаагчид хуваарьт талбайд 30 ширхэг хайлаас мод тарилаа.



Геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажлыг зохион байгуулан ажиллав.



Сүмбэр сумын 4-р багийн ИНХ-д оролцон өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмших хүсэлтийн дагуу байршил тодорхойлон ажиллаж, хуралын үйл ажиллагаанд мэдээлэл хийв.

